
“РЕМИКОН” ХК-НЫ 2022 ОНЫ ЭЭЛЖИТ
“ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ”-ЫН ПРОТОКОЛ

2022 оны 04-р сарын 29

Улаанбаатар хот

“Хувьцаа эзэмшигч”-дийн хурлын

үйл ажиллагаа зохион байгуулагдсан ГАЗАР:

СХД, 20-р хороо, Ремикон ХК-ийн хурлын танхимд тоолсон болно.

Хурал эхэлсэн цаг минут:

11.00 цагт

Ц.Эрдэнэбаяр: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. “Ремикон” ХК-ийн 2022 оны ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурал эхлэхэд бэлэн боллоо.

Хурлын бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулая. Хуралд Гүйцэтгэх захирал Э. Мөнхсайхан, ТУЗ-ын нарийн бичгийн дарга Н.Энх-Очир, миний бие Ц.Эрдэнэбаяр Хурлын зохион байгуулах комиссын дарга байна.

Тооллогын комиссын дарга бичгээр ирсэн саналыг танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Ч.Мөнгөнсүх:

Хуралд нийт 12 хувьцаа эзэмшигч ирж бүртгүүлсэн бөгөөд брокер дилерийн компаниар дамжуулан бичгээр санал авах хуудсыг ирүүлсэн хувьцаа эзэмшигч байхгүй болно.

Ц.Эрдэнэбаяр Хэлэлцэх асуудлын жагсаалтыг та бүхэд танилцуулж байна. Үүнд:

1. Ремикон ХК-ийн 2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах,
2. Ремикон ХК-ийн 2022 оны санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулах,
3. Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-д заасны дагуу Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох,
4. Ремикон ХК-ийн шинэчлэн найруулсан дүрмийг батлах,
5. Ремикон ХК-иас 2021 оны санхүүгийн жилийн ашигаас Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-д заасны дагуу ногдол ашиг хувиарлахгүй талаар танилцуулах,

6. Монгол улсын Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.4-т заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагаа санхүүгийнхаа тайланг танилцуулах,

Ч. Мөнгөнсүх: Ремикон ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал нь 2022 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн 11.00 цагт эхэлж 11.20 цагт бүртгэл явагдлаа. Хуралд нийт 12 хувьцаа эзэмшигч ирж бүртгүүлсэн бөгөөд брокер дилерийн компаниар дамжуулан бичгээр санал авах хуудсыг ирүүлсэн хувьцаа эзэмшигч байхгүй болно.

Хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа хувьцааны тоо нь нийт хувьцаа эзэмшигчдийн 52.57 % хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 69.1-д заасан Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно гэсэн заалтыг хангаж байна.

Ц.Эрдэнэбаяр Ингээд ХЭХурал нээснийг мэдэгдье.

Ц.Эрдэнэбаяр: Нэгдүгээр хэлэлцэх асуудал буюу компанийн 2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг Гүйцэтгэх захирал Э. Мөнхсайхан захирал танилцуулах болно.

Э. Мөнхсайхан: Ремикон ХК-ийн 2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг танилцуулав. /хавсралт №1/

Ц.Эрдэнэбаяр: За баярлалаа. Танилцуулгатай холбоотойгоор асууж тодруулах зүйл байна уу?

Д. Энхтуяа: Компанийн аудитлагдсан тайлан яагаад гараагүй байна вэ?

Ерөнхий нягтлан бодогч: Аудитын байгууллагатай гэрээ хийгдсэн боловч аудитын байгууллагын ажлын ачааллаас хамаарч манай байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд аудит хийх хугацааг 07 дугаар сар гэж тохиролцоод байна. Иймд бид тухайн хугацаанд сонин болон хөрөнгий биржийн сайт дээр тайлан гармагц хувьцаа эзэмшигчиддээ мэдээллэх болноо.

Э. Мөнхсайхан: Ремикон ХК-ийн 2022 оны санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулав. /Хавсралт№2/

Ц.Эрдэнэбаяр: За баярлалаа. Танилцуулгатай холбоотойгоор асууж тодруулах зүйл байна уу? Асууж тодруулах зүйл байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудалаа танилцуулна уу.

Н. Энх-Очир: Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-д заасны дагуу Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай ТУЗ-ын тогтоолыг танилцуулав. /Хавсралт №3/

Ц.Эрдэнэбаяр: За баярлалаа. Танилцуулгатай холбоотойгоор асууж тодруулах зүйл байна уу?

Д. Энхтуяа: Дараагийн жилийн ТУЗ гишүүд сонгох танилцуулгад ТУЗ-ийн гишүүдийн төлөөллийг заавал хамруулж байна уу. Биечлэн ирж байхыг уламжилж өгнө үү.

Ц.Эрдэнэбаяр: За баярлалаа. Таны саналыг хүлээн авлаа. Асууж тодруулах өөр зүйл байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудалаа танилцуулна уу.

Н. Энх-Очир: Хуралд хүрэлцэн ирсэн хийт хувьцаа эзэмшигчиддээ баярлалаа. Тайланг уншиж танилцуулав. Ремикон ХК-ийн шинэчлэн найруулсан дүрмийг батлах тухай ТУЗ-ийн тогтоолыг болон өөрчлөлт оруулсан “Дүрэм” танилцуулав. /Хавсралт№4/

Ц.Эрдэнэбаяр: За баярлалаа. Дүрмийн өөрчлөлттэй холбоотойгоор асууж тодруулах зүйл байна уу? Асууж тодруулах зүйл байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудалаа танилцуулна уу.

Н. Энх-Очир: Ремикон ХК-иас 2021 оны санхүүгийн жилийн ашигаас Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-д заасны дагуу ногдол ашиг хувиарлахгүй талаар ТУЗ-ийн тогтоолыг танилцуулав.

Ц.Эрдэнэбаяр: За баярлалаа. Тогтоолтой холбоотойгоор асууж тодруулах зүйл байна уу? Асууж тодруулах зүйл байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудалаа танилцуулна уу.

Н. Энх-Очир: Монгол улсын Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.4-т заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагаа санхүүгийнхаа тайланг танилцуулав.

Ц. Эрдэнэбаяр: Дээрхи асуудалтай холбогдуулан асууж тодруудах зүйл байна уу? Асууж тодруулах зүйл байхгүй бол хурлын санал авах үйл ажиллагаа явагдана. Саналын хуудас хэрхэн бөглөх бүтэц зэргийг Н. Энх-Очир тайлбарлана.

Н. Энх-Очир: Саналын хуудас хэрхэн бөглөх талаар зөвлөмж өгөв.

Ц.Эрдэнэбаяр: За тэгэхээр та бүхэн саналаа өгөөд санал тоолох комисст шилжүүлнэ. Хуралтай холбогдуулан өдрийн хоол бэлдсэн бөгөөд хоолны завсарлага 30 минут үргэлжлэх болно. Энэ хугацаанд тооллогийн комисс дүгнэлтээ гаргана уу.

Хурлын завсарлага 30 минут үргэлжлэв.

Тооллогын комиссын дарга Ч.Мөнгөнсүх:

ХЭХурлаар хэлэлцсэн асуудлын хүрээнд санал хураалт явуулахаднийт 12 хүний бүрэлдэхүүнтэй байснаас 12 саналыг хүчинтэйд тооцож 0 саналын хуудсыг хүчингүйд тооцсон болно. Санал хураалтын үр дүнд:

Нэг дэх асуудал компанийн 2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцэн Ремикон ХК-ийн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах талаар байгаа. Үүнд 12 хүн саналын эрхээр 100% зөвшөөрсөн саналыг бүртгэлээ.

Дараагийн асуудал нь ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудалд хувьцаа эзэмшигчид өөр өөрсдийн саналын эрхтэй хувьцааг ТУЗ-ийн гишүүдэд хувааж санал өгсөн байна. Ингээд Хараат гишүүдэд: Х.Гантулга, Ц.Эрдэнэбаяр, Ч.Мөнгөнсүх, Э.Мөнхсайхан, Б.Батсайхан, Х.Хашчимэг, Хараат бус гишүүдэд: Р. Ганхуяг, С.Баянмөнх, Д. Алтанхуяг нар 100% саналтайгаар ТУЗ-ийн гишүүдээр сонгогдсон байна.

Дүрэм шинэчлэн найрулж батлах асуудал нь 12 хүний саналын эрхээр 100% зөвшөөрсөн саналыг бүртгэлээ.

Ц.Эрдэнэбаяр: Ингээд санал хураалтын дүнгээс үндэслэн гарсан ХЭХ-ын тогтоолуудыг уншиж танилцуулан хурал хаасныг мэдэгдэв.

ХУРЛЫН ДАРГА

Ц.ЭРДЭНЭБАЯР